

Чуулганы мэдээ



Бошиглогчийн хэлсэн амьдралын сургамжууд



Ерөнхийлөгч Нэлсон энэ жил 99 нас хүрч байна! Тэр бараг 100 жил амьдрахдаа олж авсан сургамжуудаасаа хэлсэн үгтээ хуваалцсан. Түүний юу заасныг 2-р хуудаснаас уншаарай.



“Есүс Христийн сайн мэдээ бол Тэнгэрлэг Эцэг биднийг ямар хүмүүс болохыг хүсдэг шиг тийм хүмүүс хэрхэн болохыг бидэнд харуулдаг төлөвлөгөө юм.”

Тэргүүн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Даллин Х.Өүкс

“Есүс бол Христ. Тэр бол бидний Аврагч, бидний Гэтэлгэгч. Тэр бидний хамгийн сайн найз.”

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч, ерөнхийлөгч М.Рассэлл Баллард



“Есүс Христийн ачаар бүх зүйл сайхан болно.”

Хүүхдийн хэсгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн 1-р зөвлөх Эйми А.Врайт эгч



Аравны нэг ба өргөлүүд

Бид чуулганы үеэр Сүм бидний аравны нэгийн мөнгө болон хандивыг дэлхий даяарх хүмүүсийг адислахад хэрхэн зарцуулдаг тухай мэдээж авсан!

- Өнгөрсөн жил тусламж хэрэгтэй хүмүүсийг адислахад **1 тэрвум** гаруй америк долларыг зарцуулжээ.
- Үүнээс гадна тусламж хэрэгтэй хүүхэд, эхчүүдэд **54 сая** америк доллар зориулжээ.
- Аравны нэг нь **414** номлолын **71000** гаруй номлогчидг дэмжлэг үзүүлж байна.
- Мөн аравны нэг нь **195** улс орон, бүс нутагт **30000** цуглааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлдэг.



Дэлхий даяар ерөнхий чуулганыг үзсэн нь



Цагийн зөрөөнөөс болоод бид чуулганы өглөөний хуралдааныг орой үздэг. Ерөнхийлөгч Нэлсон шинэ ариун сүмүүдийг зарлахад бид маш их баяртай байсан!

София Д., 11 настай, Словакийн Братислава



Чуулган үзсэнээр би Есүс Христэд ойртох хүсэлтэй болсон. Тэр Сайн Хоньчин ба Тэр биднийг, Өөрийн хоньдыг анхаарч халамжилдаг. Бид заримдаа бага зэрэг хол газар луу тэнүүчилдэг. Гэвч Тэр үргэлж биднийг хайж ирдэг.

Эфрайн С., 9 настай, Аргентины Сан Хуан



Бид дэлгүүрээс амттай юм худалдан авч мөн амарч чуулгандаа бэлтгэдэг. Ингэснээр бид чуулганы дундуур унтахгүй. Бид ойлгохын тулд гэр бүлээрээ залбирч мөн судраас уншдаг. Би амьд бошиглогчийн үгсэд чих тавьж, Бурханы үгийг сонсохдоо үргэлж баяртай байдаг.

Рунакорвашэ С., 7 настай, Малави Өмнөд хэсэг

20 ариун сүм!

Чуулган дээр шинээр баригдах 20 ариун сүмийг зарлав! Газрын зургийг ашиглан шинээр баригдах ариун сүм тус бүрийн байршлыг олоорой. Нэг бүрийг нь олсныхоо дараа уг ариун сүмийн нэртэй хэсгийг будна уу.

